



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/404

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.2 дахь заалт, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийж батлах тухай" 04 дүгээр тогтоол, "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Уранбямба (Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Хулан (Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Б.Мөнхбат (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа)

Б.Лхагвамандал (Эрдэнэдалай сумын Засаг дарга)

Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

С.Болоржаргал (Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

З.Солонго (Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Х.Мөнхсаруул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ажлын хэсгээр хэлэлцэн зохион байгуулж тайлагнахыг

481210570

аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Түвшинжаргал), Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ